

И.Я.КОРОСТОВЕЦИЙН ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН ТҮҮХ

Ольга Бакич*

Миний эрдмийн ажлын гол сэдэв бол Хятадад тухайлан Харбин хотод аж төрдөг байсан орос хүмүүсийн амьдралын түүх юм. 1980-1990 онуудад Харбин болон Зүүн хойт Хятадад амьдарч байсан олон оросууд Австрали, АНУ, Канад болон Европын зарим орнуудад шилжин суурьшсан байдаг. Харбин болон Хятадад амьдарч байсан тэдний амьжиргааны талаар өөрсдийнх нь яриаг сонсч, тэдэнтэй нүүр учран ярилцах завшаан надад тохиосон. Энэ нь миний хувьд, зөвхөн үйл явдал, цаг хугацааны төдийгүй тэдний жинхэнэ үнэн амьдрал, хувь заяаны тухай түүх байв. Ази дахь орос хүмүүсийн тухай хамгийн олон төрлийн материалыг бүх түвшний судлаачид болон сонирхогч хүмүүст эх сурвалж болгох зорилгоор цуглуулж ирсэн бөгөөд одоо ч цуглуулсаар байна. 1994-2000 онд “Ази дахь Оросууд” хэмээх сэтгүүлийн долоон дугаарт дээрх цуглуулсан материалуудын зарим хэсгийг хэвлэн нийтлэх боломж олдсон билээ.

Тэдгээр материалуудын дотор Иван Яковлевич Коростовецийн өдрийн тэмдэглэл багтсан юм. Энэ өдрийн тэмдэглэлийг хуучин Харбинд амьдарч байсан нэг орос хүн надад итгэж өгсөн бөгөөд Австрали, Канад, АНУ, Европод хэвлэж нийтлэхийг санал болгож байв. Энэ өдрийн тэмдэглэлийг түүнд Коростовецын хүү Флавий Ивановичид дамжуулж өгсний дагуу түүнийг хэвлэн нийтлэх арга зам олохыг хүсэн итгэж өгсөн. Флавий Иванович өөрөө болон түүнийг өгсөн нэгэн орос хүн аль аль нь энэ өдрийн тэмдэглэлийг хэвлүүлж чадаагүй байв. Тэд уг өдрийн тэмдэглэлийг англи хэлээр орчуулж хэвлэхээр завдсан боловч орчуулга нь угаасаа болхи, маш муу болсон учир хэвлүүлж чадаагүй байлаа. Тэр орчуулга нь бүхэлдээ тухайн өдрийн тэмдэглэлийн нийт утга санаа үнэ цэнийг алдагдуулсан байлаа. Флавий Ивановичийн нас эцэлсний дараагаар энэ өдрийн тэмдэглэл нь Харбины оршин суугч өөр нэг орос хүний гарт олон жил хадгалагдаж байжээ. Би тэр тэмдэглэлийг нь уншиж үзэхэд, 1912 онд Орос, Монголын хооронд байгуулсан гэрээний бүхий л нөхцөл байдлын талаар өгүүлсэн маш үнэ цэнэтэй баримт бичиг болохыг олж мэдсэн. Тэр тэмдэглэл нь Монголд Оросыг төлөөлсөн Элчин сайд И.Я.Коростовецийн өөрийнх нь тухай өгүүлсэн тэмдэглэл байв.

Түүнийг хэвлэн нийтлэх шаардлагатай гэдгийг би ойлгосон. Энэ нь чухам үнэндээ, дэлхий дахинаар тархсан орос хүмүүсийн гунигтай түүхийг илтгэн харуулдаг олон баримтыг цуглуулж байсны нэг нь энэ бөлгөө. Би тэр тэмдэглэлийг хэвлүүлэхийг их хичээсэн боловч эхний удаад хэвлүүлэх боломж олдоогүй юм. Англи хэлний хэвлэлийн газар тэр өдрийн тэмдэглэлийг орос хэлээр хэвлэхийг огтхон ч хүсэхгүй байв. Харин орос хэвлэхийн газар түүнийг хэвлэх нь их гарлагатай ашиггүй байсан бөгөөд надаас их хэмжээний мөнгө

* Ольга Бакич - Канадын Торонто их сургуулийн профессор

шаардаж байлаа. Тиймээс “Азийн орос хүмүүс” хэмээх жил тутмын сэтгүүлд уг өдрийн тэмдэглэлийг хэсэг хэсгээр нь нийтлүүлэхээр шийдсэн. Тэгтэл дахин нэг асуудал гарч ирлээ. Миний нөгөө тэмдэглэлийг хадгалж байсан орос хүн маань насан өөд болов. Түүний өсвөр насны хүүхдүүд нь уг өдрийн тэмдэглэлийг хэвлүүлэхийг зөвшөөрөхгүй байсан нь энэ тэмдэглэл дотор хятадын тухай эрс шүүмжлэлттэй үг өгүүлбэр олон байгаа нь тэдний болгоомжлох шаалтгаан болсон байна. Тэд нартай олон дахин санал бодлоо солилцсоны эцэст энэ гэр бүлийн нэр усыг хэзээ ч ил гаргаж илчлэхгүй байхаар тохиролцсон билээ. Тэгтэл бас “Азийн орос хүмүүс” хэмээх жил тутмын сэтгүүлийг хэвлэн гаргах явдал ихээхэн бэрхшээлтэй болчихвоо.

Торонтогийн Их Сургууль над бага хэмжээний цалин өгч байсан учраас би энэ сэтгүүлийн эхний дугаарыг гаргахын тулд өөрийн мөнгийг хуримтлуулах шаардлагатай байв. Бас Харбинд оршин суугч зарим орос хүмүүс их биш ч гэсэн зохих хэмжээний хандив өгч билээ. Энэ бүхний дүнд сэтгүүлийн анхны дугаарыг цөөн тоогоор гаргах болсон. Тэднийгээ борлуулсан орлого болон Их Сургуулиас өгдөг цалингаар дараа дараагийн дугааруудыг хэвлэдэг боллоо. Тийнхүү хэвлэлийн асуудал нааштай шийдэгдэв. Миний ингэж дугааруудын төлбөрийн тухай яриад байгаа маань зөвхөн хэвлэлийн зардал юм шүү дээ. Компьютерт шивэх, хэвлэлийн загвар гаргах зэрэг бүх ажиллагааг би өөрөө оройн цагаар хийдэг байв. Бас төрөл бүрийн хаягаар сэтгүүлийн дугаараа би өөрөө илгээдэг байсан. Тийнхүү долоон дугаарыг гаргах тэр мөчид Торонтогийн Их Сургууль сэтгүүл хэвлэхэд зориулж өгдөг зардлаа зогсоочихлоо. Түүгээр уг сэтгүүлийг цаашид хэвлэн нийтлэх ажил дуусгавар болсон юм.

Коростовецийн өдрийн тэмдэглэлийг бичгийн машинаар бичсэнийг нь компьютерт суулгаж шивэх бүх техник ажлыг эрхэлж байсан ажлын хажуугаар хийж гүйцэтгэхэд олон шөнийг зарцуулсан. Түүнийг бичгийн машинаар бичсэн тэмдэглэлийг харахад нь И.Я.Коростовец өөрөө өдрийн тэмдэглэлээ хэвлэлд бэлтгэж байсан нь илт байв. Тэр машинаар бичсэн тэмдэглэлдээ олон газар оруулга хийж засварласан байсан. Тэр үнэ цэнэтэй баримт бичгийн жинхэнэ эхийг хадгалах журмыг баримтлан “Азийн орос хүмүүс” сэтгүүлд хэсэг хэсгээр нь хэвлүүлэх боломж гарав.

Чингэхдээ, Коростовецийн засварласан үг өгүүлбэрийг тэр чигээр нь хашилтанд хийн хэвлэх зарчмыг баримталж ажилласан. Тийнхүү Коростовецийн энэ өдрийн тэмдэглэл “Азийн орос хүмүүс” сэтгүүлийн 1994 оны №3-д тус тус нийтлэгдсэн юм. Өдрийн тэмдэглэлийн нэг хэсэгт хэдэн хуудас материал дутуу байсан нь миний сэтгэлийг зовоож байлаа. “Азийн орос хүмүүс” сэтгүүлийн эхний гурван дугаар ийнхүү хэвлэгдсэний дараа Сан-Франциско хотын Оросын соёлын музейнд тэр дутсан материалууд байна гэдгийг би гэнэт олж мэдлээ. Ямар замаар тэр материалууд тэнд очсон нь тун тодорхойгүй. Музейн ажилтнууд энэ музейд Коростовецийн өдрийн тэмдэглэл, хувийн архив аль нь ч байхгүй, байгаагүй гэж ярьдаг. Түүний өдрийн тэмдэглэлээс энэ материал яагаад тэнд хадгалагдаж буйг хэлэхэд ч хэцүү. Харин би тэрхүү машинаар бичсэн бүх

бичвэрийг компьютерт шивж суулгах ажилд олон шөнийг зарцуулсан гэдгийг дахин хэлье. Тэр музейд байсан материалуудыг хуулбарлаж авах талаар их хөөцөлдөж, удирдлагыг нь ятгаж байж зөвшөөрүүлж чадсан. Тэгээд энэ материалуудыг сэтгүүлийнхээ 1998 оны №5-д нийтлүүлсэн билээ.

Профессор О.Батсайхан энэ өдрийн тэмдэглэлийг тусгай ном болгон Монголд хэвлэх төлөвлөгөөний тухай над захиа бичсэн билээ. Ийнхүү И.Я.Коростовецийн өдрийн тэмдэглэл 100 жилийн дараа түүний ажиллаж амьдарч байсан Монгол улсад хэвлэгдэн гарах сайхан боломж олдсонд би тун их баярлан, талархаж байна.